



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот


Ажил, албан тушаалын жагсаалт,
үндсэн цалин, нэмэгдэл хөлсийг
шинэчлэн батлах тухай


Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 49 дүгээр зүйлийн 49.1.3, 101 дүгээр зүйлийн 101.1, 102 дугаар зүйлийн 102.1.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 382 дугаар тогтоол, 2023 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дүгээр тогтоолын 2, 6, 7 дугаар хавсралт, 2025 оны 224, 225 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2026 оны “Албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” А/11 дүгээр тушаал, Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны А/294 дүгээр тушаалаар батлагдсан “Эмгэг судлалын үндэсний төвийн дүрэм”-ийн 4.5.3 дахь заалт, Эмгэг судлалын үндэсний төвийн бүтэц, үйл ажиллагааны MNS 6676:2017 стандартыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эмгэг судлалын үндэсний төвийн “Ажил, албан тушаалын жагсаалт”-ыг нэгдүгээр, “Ажилтнуудыг ажил, албан тушаалд байршуулсан жагсаалт, албан тушаалын зэрэглэл, үндсэн цалингийн хэмжээ”-г хоёрдугаар, резидент эмч нарын цалингийн хэмжээг гуравдугаар, ажил албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачаалал нэмэгдүүлэн ажиллуулах ажилтны нэмэгдэл хөлсний хэмжээг дөрөвдүгээр хавсралтаар тус тус шинэчлэн баталж, тогтоосугай.

2.Энэхүү тушаалыг 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн мөрдөж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн алба (Б.Отгонгэрэл), Санхүү, эдийн засгийн алба (Ц.Должинсүрэн) нарт үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эмгэг судлалын үндэсний төвийн захирлын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн “Албан тушаалын жагсаалт, үндсэн цалингийн хэмжээг тогтоох тухай” А/01 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.ГАНЗОРИГ



14.100100~16

Эмгэг судлалын үндэсний төвийн
захирлын 2026 оны 01 дүгээр сарын 02
-ны өдрийн А.01 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН АЖИЛ,
АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

№	Албан тушаал	YAMAT	Орон тоо
1	Захирал	1342-02	1
2	Чанарын албаны дарга	1342-15	1
3	Эмгэг судлалын тусламж, үйлчилгээний албаны дарга	1342-15	1
4	Эс судлалын эрт илрүүлгийн албаны дарга	1342-15	1
5	Сургалт, судалгаа, эрдэм шинжилгээ, гадаад харилцааны албаны дарга	1223-11	1
6	Бодлого, төлөвлөлтийн албаны дарга	1213-11	1
7	Санхүү, эдийн засгийн албаны дарга	1213-13	1
8	Лабораторийн эрхлэгч	2212-02	1
9	Тасгийн эрхлэгч	2212-02	2
10	Зөвлөх эмч	2212-02	1
11	Анатомийн эмгэг судлаач эмч	2212-02	18
12	Эсийн эмгэг судлаач эмч	2212-02	1
13	Био-анагаахын мэргэжилтэн, анагаахын молекул биологи судлалын	2269-04	3
14	Био-анагаахын мэргэжилтэн, эс судлалын	2269-08	2
15	Эмгэг судлалын лабораторийн техникч	3212-16	15
16	Чанар, аюулгүй байдал, эрсдэлийн менежер	1213-14	1
17	Биостатистикч, эрүүл мэндийн даатгалын эмч	2269-11	1
18	Эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн ажилтан	4226-11	1
19	Хүний нөөцийн менежер	1212-13	1
20	Эрүүл мэндийн удирдлагын мэдээлэл, сургалтын мэргэжилтэн	2269-10	1
21	Эрүүл мэндийн эдийн засагч	2269-18	1
	Эмнэлгийн тоног төхөөрөмж хариуцсан ажилтан	3119	
22	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	3257-13	1
	Цахилгаанчин	7411-11	
23	Ерөнхий нягтлан бодогч	2411-13	1
24	Нягтлан бодогч	2411-17	1
25	Мэдээлэл, технологийн сүлжээний инженер	2523-11	1
26	Архив-бичиг хэргийн эрхлэгч	4110-12	1
27	Зохион байгуулагч, нярав	4321-11	1
28	Хуулийн мэргэжилтэн	2616-14	1
29	Түргэн тусламжийн жолооч	8322-16	2
30	Халдваргүйжүүлэгч, лабораторийн багаж хэрэгсэл, шил сав угаагч	9121	3
	Нийт		68